

**“Фронттиер Лэнд Групп” ХК-ийн
Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлын ТЭМДЭГЛЭЛ**

2017 оны 4 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

“Фронттиер Лэнд Групп” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг (цаашид ХЭЭХ гэх) 2017 оны 4 сарын 28-нд Улаанбаатар хотод зарлан хуралдуулав. Хурал Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт орших Пума Импераил Зочид Буудлын 2 дугаар давхрын хурлын бага зааланд 18 цаг 10 минутад эхлэв.

Хурлын ирц 91,64%-тай бүрдсэн болохыг Хурлын Тооллогын Комиссын Дарга Т. Булган танилцуулав.

Хурлын ирц бүрдсэн тул Хурлын дарга Г. Оюунболд хурлыг нээн, компанийн Гүйцэтгэх захирал М.Төвшин ХЭЭХ-аар хэлэлцэх асуудлуудыг танилцуулсан ба хуралд оролцогсод асуудлуудаа дор бүр нь хэлэлцэн санал асуулгаа авахаар тохиров.

Хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
2. Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөөг батлах
3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх асуудлыг хэлэлцэж, батлах
4. “ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах асуудлыг хэлэлцэж, батлах
5. Компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах болон шаардах эрх хэрэгжүүлэх тухай хэлэлцэх
6. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилсэн найруулгыг батлах
7. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид ТУЗ гэх) гишүүдийг сонгох
8. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 цалин, урамшуулал, үйл ажиллагааны төсвийг батлах
9. Ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсэн тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
10. Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг батлах
11. Бусад

“Фронттиер Лэнд Групп” ХК -ийн ТУЗ-ийн Дарга Эльёр Хасанов Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулав. 2016 оны хувьд, улс орны эдийн засаг хүндрэл үргэлжилсэн, ДНБ-ий өсөлт илт удаашран, эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа хумигдаж, гадаадын хөрөнгө оруулалт өмнөх жилүүдтэй харьцуулахад огцом буурч, хөрөнгө оруулагчдын итгэл суларсан хүндхэн жил байлаа.

Дотоод, гадаад хүчин зүйлсээс улбаалсан эдийн засгийн хүндрэлтэй байдал бүхий л салбарт хүчтэй мэдрэгдэж, үүний дотор үл хөдлөх хөрөнгийн зах зээл, оффис, үйлчилгээний талбай, орон сууцны түрээсийн зах зээлд мэдэгдэхүйц нөлөөлж байсан ч 2016 оны жилийн эцсийн байдлаар компани нь Реженси Резиденс дахь нийт оффис болон үйлчилгээний талбайнууд, БаянМонгол хороолол дахь компанийн эзэмшлийн орон сууцнуудыг түрээслэгчтэй байлгаж чадсан нь сайшаалтай байна.

Компанийн удирдлага тайлант хугацааны туршид түрээслэгчидтэй нягт хамтран ажиллаж, тэдний санал хүсэлтийн дагуу түрээслүүлэгчийн хувьд илүү их үйлчилгээ үзүүлж ажилласан нь түрээслэгчдээ хадгалж үлдэхэд нөлөөлсөн гэж дүгнэж байна.

Компанийн удирдлагын 2016 онд хийж гүйцэтгэсэн ажлаас дурдвал:

Реженси Резиденс цогцолборын зүүн жигүүрийн хоёр, гуравдугаар давхрын оффис, үйлчилгээний талбайн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хийх зорилгоор ТУЗ-ийн тогтоолын дагуу Худалдаа Хөгжлийн Банкнаас 500 сая төгрөгийн 3 жилийн хугацаатай зээлийг 2016 оны 4-р сард амжилттай авсан. Үндсэн зээл болон зээлийн хүүнд сар бүр 20 орчим сая төгрөг буюу 2016 оны эцсийн байдлаар нийт 154.5 сая төгрөгийг хугацаанд нь төлсөн байна.

Компанийн түрээслэгч Бүгд Найрамдахчуудын Хүрээлэнгээс оффисийн талбайг томсгож өгөх, боломжгүй бол өөр оффис рүү нүүх болсон тухай шаардлага тавьсны дагуу хөрш түрээслэгч QMC компанитай харилцан зөвшилцсөнөөр тэдний оффисийн талбайгаас Бүгд Найрамдахчуудын хүрээлэнд тасалж өгч томсгож асуудлыг шийдвэрлэсэн.

Түрээслэгч Глобал сангийн зүүн тийш харсан нар тусдаггүй цонхнуудыг давхарлан шиллэж, дулаан алдагдалтыг багасгасан байна.

2-р давхрын эрэгтэй, эмэгтэй жорлонгуудыг хуруу мэдрэгчтэй цоожоор тоногосноор, зөвхөн манай түрээслэгчид орох боломжтой болж, түрээслэгчдийн тав тухыг хангасан байна.

Түрээслэгчдийн хүсэлтийн дагуу аяга таваг угаах угаалтуурын өрөөг коридорт суурилуулж өгснөөр түрээслэгчдийн тав тухыг ханган, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаж өгсөн.

Түрээслэгч Франц рестораны хүсэлтийн дагуу уг ресторанд агааржуулалтын систем суурилуулж өгснөөр, хэвшүү багасч, үйлчлүүлэгчид тав тухтай үйлчлүүлэх боломжтой болсон.

Компанийн удирдлагын зүгээс Реженси Резиденс цогцолборын СӨХ-д удаа дараа хүсэлт гаргасны хүчинд, уг цогцолборын урд талын гадна хаалганд давхар хаалга хийлгүүлж, дулаан алдагдалтыг багасган, нэгдүгээр давхрын түрээслэгчдийн тав тухыг хангахад дөхөмтэй болсон.

Түрээслэгч Донна Скарпиа гутлын дэлгүүрийн тавиуруудын ард далдлагдсан паарнуудад шугам хоолойн дахин төлөвлөлт хийснээр үйлчилгээний талбайд ил гаргаж өгч, дулаан алдагдалтыг багасгасан байна.

Реженси Резиденс цогцолбор дахь нэгдүгээр давхрын түрээслэгч болох Хаан банкны салбарын шилэн хаалга суулт өгч, онгойж хаагдахад хүндрэлтэй болж, улмаар нурж унах ч аюултай байсныг яаралтай арга хэмжээ авч, төмөр раамтай шинэ шилэн хаалтаар сольсноор болзошгүй аюул, ослоос сэргийлсэн байна.

Баянмонгол хороолол дахь компанийн эзэмшлийн орон сууцнуудын түрээслэгчдийн санал хүсэлтийн дагуу түргэн шуурхай ажилласан байна.

Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд өгөх дүгнэлт:

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооноос санал болгосны дагуу ТУЗ 2016 оны жилийн эцсийн тайланд аудит хийх хараат бус аудитын компаниар Сүлд Аудит ХХК-ийг ажиллуулах шийдвэр гаргасан. Сүлд Аудит ХХК нь СЗХ-оос эрх авсан, итгэмжлэгдсэн аудитын компани бөгөөд тус компанийн 2013-2015 онуудын жилийн эцсийн тайланд аудит хийж байсан туршлагатай юм. 2016 онд хийсэн хараат бус аудитын тайлангаар зөрчилгүй буюу компанийн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байна гэсэн санал дүгнэлт өгсөн байна.

Компанийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайланг 2016.01.01-2016.12.31 –ний байдлаар өссөн дүнгээр Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж заавар журам, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлан хүлээн авах эрх бүхий газруудад хуулийн хугацаанд хүргүүлдэг байна.

Мөн компанийн дотоод гадаад хөрөнгө оруулагчид, мэдээлэл хүлээн авагчид хүртээмжтэй болгох үүднээс компанийн веб сайтад байршуулан мэдээлэл шуурхай авах боломжоор ханган ажиллаж байна.

1. Нийт хөрөнгө

Нийт хөрөнгө буюу тэнцэл нь Жилийн эхэнд байсан нийт хөрөнгө 16.353,9 сая төгрөгөөс жилийн эцсийн байдлаар 16.644,3 сая төгрөг болж өссөн байна. Үүнд 2016 оны жилийн эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгө 54.55% хувийг, эргэлтийн бус хөрөнгө 45.45% хувийг эзэлж байгаа нь санхүүгийн хувьд тогтвортой үйл ажиллагаа явагдсан. Эргэлтийн хөрөнгө болон үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгөө, удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу борлуулж хөрөнгө оруулалтад оруулж хөрөнгө худалдаж авах, бусад үйл ажиллагааг санхүүжүүлэн төлбөрийн чадварын хувьд бүрэн боломжтой юм.

2016.12.31- ний байдлаар үл хөдлөх хөрөнгө худалдан авах гэрээний дагуу урьдчилгаа төлбөрт болон хөрөнгө оруулалтад 747 сая төгрөг шилжүүлж, урьдчилж төлөгдсөн төлбөрийг удирдлагын шийдвэрийн дагуу 2015 онд богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд 7130,0 мянган төгрөгөөр бүртгэж нийт богино хугацаат хөрөнгө оруулалтаа 2016 оны 12 -р сарын 31 -р 7877,05 сая төгрөг болгож ирээдүйд хөрөнгө оруулалтаас ашиг хүртэж, хувыцаа эзэмшигчдийн өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой. Өглогүүдийн хувьд ихэвчлэн түрээсийн барьцаа болох хэвийн хэмжээний төлбөр хамаарч байна.

2. Орлогын тайлан

Үйл ажиллагааны орлогын тухайд 2016 оны жилийн эцсийн байдлаар 724,95 сая төгрөг байна.

Үйл ажиллагааны зардлын тухайд 2016 онд 648,2 сая төгрөгийн зардал гарсан. 2016 оны зардалд тодорхой хэмжээгээр нөлөөлөл үзүүлсэн томоохон хэмжээний зардлууд нь оффис зориулалттай үл хөдлөх хөрөнгийг элэгдүүлж эхэлсэнтэй холбоотойгоор хэвийн хэмжээний элэгдлийн зардал 22,33 хувь /144.79 сая төгрөг/, үйлчилгээний зардал, бусад зардалд газрын болон үл хөдлөх хөрөнгийн татварыг тооцож төлсөн, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зээлийн хүүгийн зардал 10,9 Хувь /70.78 сая төгрөг/-р зохих хэмжээгээр нэмэгдсэн нь манай байгууллагын хувьд үйл ажиллагаагаа хэвийн явуулах, цаашид олох орлогоо нэмэгдүүлэх, байр худалдах зорилгоор өөрийн эзэмшлийн хөрөнгүүдийг сайжруулахад, засвар үйлчилгээ хийлгэх, зах зээл дээр хөрөнгийн түрээс болон үнийн уналттай холбоотойгоор тодорхой хэмжээгээр орлого болон зардлаа хэвийн хэмжээнд байлгах талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан.

3. Татварын тайлан

Манай байгууллагын хувьд Монгол улсын татварын хууль тогтоомж, заавар журмын дагуу хуулийн хугацаанд татварын тайлан гаргаж цахимаар илгээн татвараа тухай бүрд нь төлж байгаа болно.

Үүний дараа “Фронттиер Лэнд Групп” ХК -ийн Гүйцэтгэх захирал М. Төвшин 2017 оны бизнес төлөвлөгөө танилцуулахдаа: компанийн үйл ажиллагааны ерөнхий чиг, бизнесийн үндсэн үйл ажиллагаа болон зорилго нь цаашид үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн салбаруудад хөрөнгө оруулалт хийх, Улаанбаатар хот болон уул уурхайн эрэлт бүхий хот суурингуудад газар эзэмших замаар орон сууц болон арилжааны зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх, гадаадын орнуудын үл хөдлөх хөрөнгийн салбарыг судалж хөрөнгө оруулалт хийх гэх мэт төрөл бүрийн үйл ажиллагааг

эрхлэх болно. Зорилгынхоо хүрээнд компани нь оффис, худалдаа үйлчилгээ, орон сууцны барилгуудыг эзэмшиж, түрээслэх үйл ажиллагааг голчлон явуулж байна.

Компани нь Монгол улсад явуулж буй үл хөдлөх хөрөнгийн салбарын үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлэхийн зэрэгцээ, шинэ тулгар хөгжиж буй улсуудын үл хөдлөх хөрөнгийн салбаруудад нэвтрэхээр төлөвлөж байна. Компани нь 10 хүртэлх тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг шинэ тулгар хөгжиж буй зах зээлтэй улсуудын үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хийхээр төлөвлөж байна. Компани нь нарийвчилсан магадлан шинжилгээ хийсний үндсэн дээр эдгээр зорилтот хөрөнгө оруулалтуудыг хийх эсэхээ шийднэ. Эдгээр хөрөнгө оруулалтуудыг хийх гол зорилго нь ашиг олох явдал юм. Эдгээр боломжит хөрөнгө оруулалтуудыг санхүүжүүлэх гол эх үүсвэр нь дотоодын банкнуудад байршуулсан мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, дотоодын банкнуудаас авах зээл болон хувьцаа нэмж гаргаснаар татан төвлөрүүлэх хувьцаат капиталын эх үүсвэр байх юм. Хурлын дарга Хувьцаа эзэмшигчдээс асуух зүйл байгаа эсэхийг лавлав. Асуулт байхгүй учраас хурлаа цаашид үргэлжлүүлээ.

ТУЗ-ийн гишүүн Камолиддин Талипов дараагийн хоёр асуудлууд болох компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх асуудлыг хэлэлцэх, нэмэлт хувьцаа гаргах тухай танилцуулав. Сүүлийн хоёр гурван жилүүдэд хөрөнгө оруулагчдаас ирсэн хүсэлтийн дагуу нэмэлт хувьцаа гаргаж хараахан чадаагүй байгаа гол шалтгаануудыг нэг бол Монголын зах зээлийн тогтворгүй байдал юм. Иймээс нэмэлт хувьцаа гаргах эсэх нь зах зээлийн байдалтай шууд холбоотой байна. Хэрэв Монголын зах зээлийн нөхцөл байдал сайжирвал гаднын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна. Ер нь бол 10 тэрбум хүртэлх төгрөгийн хөрөнгө босгохоор төлөвлөж байна.

- Хурлын дарга Г.Оюунболд: Одоогийн нөхцөл байдал хэцүү байна. Өнгөрсөн жил Монгол Улсын сангийн сайд Монголын талаар сөрөг мэдээллүүд хийснээр олон улсад Монгол Улсыг сонирхох хөрөнгө оруулагчдын сонирхол буурсан. Дээрээс нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос шийдвэр гарахгүй байна. Ерөнхийдөө өнөөдрийн байдлаар Монгол Улсын хувьцаат компанид хөрөнгө оруулах хүсэлтэй хөрөнгө оруулалтын сангууд байгаа гэдэгт итгэлтэй биш байна. Нэмэлт хувьцаа гаргахад маш хэцүү байна. Иймээс нэмэлт хувьцаа гаргаж чадахгүй байхыг бас үгүйсгэхгүй. Гэхдээ нэмэлт хувьцаа гаргахыг хичээн ажиллана. ХЭХ-ыг олон дахин хуралдуулах нь өртөг өндөртэй тусаж байгаагаас гадна давхар хугацаа алдана гэж үзэж байгаа учраас аз нь таарвал нэмэлт хувьцаа гаргаж магадгүй гэж үзээд гаргахаар шийдвэрлэн бусад төсөл дүгнэлтийг батлах эрхийг ТУЗ-д даалган өгөхийг санал болгов. Мөн хувь нийлүүлсэн хөрөнгийн талаар дурдахад нэрлэсэн үнийн талаар яригдана. Энэ тохиолдолд аль болох компани болон Хувьцаа эзэмшигчдийн аль алиных нь хувьд аль болох хохирол багатай боломжит аргаар шийдэх хэрэгтэй. Нэрлэсэн үнийг бууруулах, хувьцаа хуваах, нэгтгэх зэрэг аргуудаас сонгон нэрлэсэн үнэ тогтоох асуудлыг шийдвэрлэх үүргийг ТУЗ-д даалгах санал гаргав.

- Гүйцэтгэх захирал М. Төвшин: Нэмж хэлэхэд Монгол Улсын зээлжих зэрэглэл буурснаас үүдэн олон улсын хөрөнгө оруулагчдын итгэл буурлаа. Үүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт ч буурлаа. Мөн улсын хэмжээнд дампуурлын хэмжээнд хүрээд байхад Олон Улсын Валютын Сангийн Өргөжүүлсэн хөтөлбөр батлагдлаа. Иймээс шинэ хөрөнгө оруулалт олоход хүндрэлтэй байгаад санал нэг байна. Мөн нэрлэсэн үнийг өөрчлөх олон арга байдаг ч хувьцааг хуваах шийдвэрийг илүүд үзэж байна. Учир нь түргэн борлогдох чадвар нь нэмэгддэг учраас хувьцааны үнэ өсөх магадлал өндөр байдаг.
- Хурлын дарга Г.Оюунболд: Нэмэлт хувьцаа гаргах асуудалтай хамт компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах болон шаардах эрх хэрэгжүүлэх тухай асуудал гарч ирнэ. Энэ тохиолдолд компани төлбөрийн чадвартай үлдэх ёстой. Тэгэхээр хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах болон шаардах эрх хэрэгжүүлэхийг зөвшөөрч харин тухайн үед нь журмыг нь батлан шийдэх асуудлыг ТУЗ-д үүрэг болгох санал гаргав.

Дараагийн асуудал болох компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилсэн найруулгыг батлах тухай гүйцэтгэх захирал М. Төвшин: Улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх мөн нэмэлт хувьцаа гаргасан тохиолдолд нэрлэсэн үнэ, гаргасан хувьцааны тоо ширхэг өөрчлөгдөнө. Энэ үед нь компанийн одоогийн үйл ажиллагааны чиглэл дээр нэмэлтээр өөрчлөлт оруулах саналтай байна гэв.

- Хурлын дарга Г.Оюунболд: Нэмэлт хувьцааг гаргахыг хүлээлгүй үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт хийвэл илүү үнэ цэнэ нэмэгдэнэ гэж харж байна. Тиймээс гүйцэтгэх удирдлагад Улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх үйл ажиллагааны чиглэлд тусгай зөвшөөрөл шаардагдахгүй үл хөдлөх хөрөнгийн худалдаа, түрээс, зуучлал, үл хөдлөх хөрөнгийн менежмент зэрэг үйл ажиллагааны төрлүүдээс нэмэх санал дэвшүүлэв. Дүрмийн шинэчилсэн найруулгын бусад зүйл дээр санал нэгдэв.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох асуудал дээр хурлын дарга Г.Оюунболд: Одоогийн байдлаар ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвшүүлэх шинэ хүний нэр ирээгүй байна. Шинэ нэр дэвшигч байвал одоо нэрээ дэвшүүлж болно гэв. Шинээр нэр дэвшигч байхгүй байсан тул ТУЗ-ийн гишүүдийг дэлгэрэнгүй танилцуулан санал хураав.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 цалин, урамшуулал, үйл ажиллагааны төсвийг батлах тухайд М. Төвшин хэвээр байлгах санал тавьсан.

- Хурлын дарга Г.Оюунболд: ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалинг энгийн гишүүдтэй нэг төвшинд болгох ба нарийн бичгийн даргын цалинг 100 мянгаар нэмэх санал гаргав.

- ТУЗ-ийн хараат бус гишүүн Д. Үнэнбат ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалинг энгийн гишүүдтэй нэг төвшинд болгох ба нарийн бичгийн даргын цалинг 100 мянгаар нэмэх санал асуудал дээр санал нэг байгаагаа илэрхийлэв.

Ногдол ашиг тараахгүй байх шийдвэрийг ТУЗ –ын гишүүн Г.Оюунболд танилцуулав. Бид алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй гэж ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Үр ашигтай ажиллаад эхлэвэл ногдол ашиг тараана гэв.

Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг батлах тухайд гүйцэтгэх захирал М. Төвшин: Жил бүр сунгаад яваад байгаа энэ гэрээний хувьд хэрэгжүүлэгч тал концессийн гэрээгээ хийгээд яваад байгаа. Мөн засаг даргын захирамжийг хүлээж байна. Тухайн захирамж манай компанийн гэрээг сунгана гэж гармагц дараа оны ХЭХ-ын өдөр хүртэл сунгах санал хурааж байна.

Ийнхүү хурлаар хэлэлцэх бүх асуудлуудыг хэлэлцэж, хувьцаа эзэмшигчдийн асуусан асуултанд хариулж, нэмэлт тодруулга хийсний дараа хурлын дэгийн дагуу Тооллогын комиссын дарга саналын хуудас бөглөх зааварчилгаа, тооллогын журмыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулаад Хурал зохион байгуулах бүрэлдэхүүн хуралд биеэр болон итгэмжлэлтэй ирсэн хувьцаа эзэмшигчдээс холбогдох журмын дагуу саналын хуудсыг хураан авч тоолов.

Саналын хуудаснуудыг нягтлан шалгаж, тооллогын нэгтгэсэн дүнг Тооллогын Комиссын дарга Т. Булган хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

Санал хураалтанд Компанийн нийт гаргасан 13,750,000 хувьцаанаас халаасны хувьцааг хассан саналын эрх бүхий нийт 13,744,342 хувьцаанаас 12,594,828 ширхэг хувьцаа буюу 91.64%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцэх 11 асуудлаар өгсөн саналын үр дүн дараах байдлаар гарсныг Т. Булган мэдэгдэв:

	Хэлэлцсэн асуудлууд	Зөвшөөрсөн саналын тоо	Хувь
1.	Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	12,594,828	100%
2.	Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөөг батлах	12,594,828	100%
3.	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх асуудлыг хэлэлцэж, батлах	12,594,828	100%
4.	“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах асуудлыг хэлэлцэж, батлах	12,594,828	100%
5.	Компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах болон шаардах эрх хэрэгжүүлэх тухай хэлэлцэх	12,594,828	100%

6.	Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилсэн найруулгыг батлах	12,594,828	100%
7.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох	12,594,828	100%
8.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 цалин, урамшуулал, үйл ажиллагааны төсвийг батлах	12,594,828	100%
9.	Ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсэн тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах	12,594,828	100%
10.	Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг батлах	10,772,375	85.53%
11.	Бусад	9,772,375	77.59%

Хурлын дарга хурал амжилттай болсныг зарлаж хурлыг хаан үг хэлээд, хуралтай холбоотой бүх бичиг баримтыг зохих журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хорбо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх болохыг мэдэгдэн хурлыг албан ёсоор 19 цаг 50 минутад хаав.



ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Г.ОЮУНБОЛД /ХУРЛЫН ДАРГА/

Г. САНЖААСҮРЭН /ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА/